

## **ХУВИЙН ТЭТГЭВРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

### **Удиртгал**

УИХ-аас 2015 онд баталж, 2017 оны 1 сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж буй Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу Мэргэжлийн нэгдсэн холбооны тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог урьдчилсан байдлаар тооцоолсон болно.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хуулийн төслийн үр нөлөөг урьдчилан тандан судлах явцад, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх явцад болон хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг тандан судлах явцад тус тус гүйцэтгэнэ. Энэ нь тодорхой харилцааг зохицуулах зорилгоор шинээр боловсруулж буй хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээр төрийн байгууллага, хуулийн этгээд болон хувь хүнд хэр хэмжээний зардал, ачаалал үүсгэх магадлалыг урьдчилан гаргах зорилготой.

Уг аргачлалын Ерөнхий зүйлийн 1.5-д заасан журмын дагуу зардлыг төрийн байгууллагын зардал, хуулийн этгээдийн зардал, иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог боловч тус хуулийн төслөөр хувь хүн, аж ахуйн нэгжид бус төрийн байгууллагад зардал үүсгэхээр байгаа тул иргэн, аж ахуйн нэгжид үүсэх зардал тооцох шаардлагагүй байна.

Хувийн тэтгэврийн тухай хуулийн төслөөр иргэнд зардал үүсгэхгүй, харин хуулийн этгээд, төрийн байгууллагад шинэ чиг үүрэг нэмэх, шинээр үүрэг хүлээлгэх зохицуулалтууд тусгасан. Хуулийн төслөөр хувийн тэтгэврийн сан шинээр үүсч тус санд шимтгэл төлөгчид буюу нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу даатгуулагч нь өөрсдийн төлж буй нийгмийн даатгалын шимтгэлийн тодорхой хувийг нийгмийн даатгалын санд төлөхгүйгээр тус санд ажил олгогчийн зүгээс шилжүүлэх, улмаар санхүүгийн зохицуулах хорооноос тус сангийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг нэмэгдэж байна.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан. Үүнд:

- Хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

**Нэг. Хувийн тэтгэврийн тухай хуулийг батлан хэрэгжүүлснээр төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардал**

Хувийн тэтгэврийн тухай хуулийг батлан хэрэгжүүлснээр төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлыг тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр нэг албан хаагчид шаардагдах зардлаар үржүүлэн тооцох замаар дараахь үе шаттайгаар гаргалаа. Үүнд:

- Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох;
- Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хугацааг тодорхойлсны үндсэн дээр шаардлагатай хүний нөөцийг хэрэгцээг тогтоох;
- Хүний нөөцтэй холбоотой гарах зардлыг урьдчилан тооцох;
- Бусад зардал буюу материаллаг зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягтлах.

### **Нэгдүгээр үе шатанд:**

Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг нэг бүрчлэн түүвэрлэн, хийж гүйцэтгэх үйл явцын дагуу уялдаа холбоог харгалзан тодорхойлсон.

Ийнхүү тодорхойлохдоо ажил үйлчилгээнд хэрэгжүүлэх, хэмжих боломжтой ажлыг хамаарууллаа. Үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг тооцохдоо төрийн байгууллагад хийгддэг адил төстэй үйлчилгээг судалж, холбогдох мэргэжилтнүүдийн ажилбарт ажлын байрны зураг авалтын үр дүнд гаргасан хугацаан дээр үндэслэн тэдгээрийн гүйцэтгэх хугацааг тодорхойлон тооцлоо.

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулах авч үзэв. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу /200 x 8/ 1600 ажлын цаг буюу /1,600 x 60/ 96000 минут ажиллана гэсэн үг.

### **1.1. Төрийн захиргааны байгууллагад үүсэх зардал тооцсон байдал**

Хувийн тэтгэврийн тухай хуулийн төсөлд Санхүүгийн зохицуулах хороо дараах шинэ чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- Хувийн тэтгэврийн сангийн захиргааны болон хөрөнгө оруулалтын зардлыг хянах;
- Хувийн тэтгэврийн сангийн өөрийн хөрөнгө болон тэтгэврийн хөрөнгийн зохистой харьцааг хянах;
- Хувийн тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих;
- Хувийн тэтгэврийн санд хяналт шалгалт хийх
- Хувийн тэтгэврийн сангийн тухай хуулийн дагуу 13 дүрэм, журам баталж мөрдүүлнэ.

Д/д	Гүйцэтгэх үүрэг чиг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа минут	х	Давтамж Жилд 1 удаа	Нийт хугацаа
4	Хувийн тэтгэврийн санд хяналт шалгалт хийх.	Материал хүлээн авах	120		1	120
		Хурал зохион байгуулах	180		1	180
		Материалыг хянах	2400		1	2400
		Газар дээр ажиллах	2400		1	2400
		Хурлаар хэлэлцүүлэх	240		1	240
		Холбогдох шийдвэр гаргаж, мэдэгдэх	10		1	10
	НИЙТ					5350
Шаардлагатай хүний нөөц = 5350 / 60 минут = 89.1 цаг / 8 = 11.1 өдөр						

Д/д	Гүйцэтгэх үүрэг чиг	Хэрэгжүүлэх ажиллагаа үйл	Хугацаа минут	х	Давтамж	Нийт хугацаа
5	Хувийн тэтгэврийн сангийн тухай хуулийн дагуу 13 дүрэм, журам баталж мөрдүүлэх, сайжруулах.	Дүрэм, журмыг боловсруулах, сайжруулах	1440		13 дүрэм	18720
		Дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавих	960		13 дүрэм * 12 удаа = 156	149760
	НИЙТ					168480
Шаардлагатай хүний нөөц = 168480 / 60 минут = 2808 цаг / 8 = 351 өдөр						

Ийнхүү үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг нэгтгэн шаардагдах нийт ажлын цагийг гаргаж уг ажлын цагт ажиллах хүний нөөцийн хэрэгцээг дараахь байдлаар гаргалаа.

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ	Жилд шаардагдах ажлын цаг	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
Төрийн захиргааны байгууллага	3479 цаг	1600	2.17

Дээрх тооцооллыг харахад төрийн захиргааны төв байгууллагад 208750 цагийн ачаалал үүсч байгаа нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд 2.17 хүн шаардлагатай байна.

Гуравдугаар үе шатны хүрээнд: Гарах зардлыг урьдчилан тооцох

Хоёрдугаар шатны хүрээнд: Үүрэг буюу ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох

д/д	Гүйцэтгэх чиг үүрэг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа минут	х	Сар бүр Жилд 12 удаа	Нийт хугацаа
1	Хувийн тэтгэврийн сангийн захиргааны болон хөрөнгө оруулалтын зардлыг хянах.	Материал хүлээн авах	10		12	120
		Материалыг хянах	960		12	11520
НИЙТ						11640
Шаардлагатай хүний нөөц = 11640 / 60 минут = 98 / 8 = 24.25 хүн						

д/д	Гүйцэтгэх чиг үүрэг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа минут	х	Сар бүр Жилд 12 удаа	Нийт хугацаа
2	Хувийн тэтгэврийн сангийн өөрийн хөрөнгө болон тэтгэврийн хөрөнгийн зохистой харьцаанд хяналт тавих.	Материал хүлээн авах	10		12	120
		Материалыг хянах	960		12	11520
НИЙТ						11640
Шаардлагатай хүний нөөц = 11640 / 60 минут = 98 / 8 = 24.25 хүн						

д/д	Гүйцэтгэх чиг үүрэг	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа минут	х	Сар бүр Жилд 12 удаа	Нийт хугацаа
3	Хувийн тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих.	Материал хүлээн авах	10		12	120
		Материалыг хянах	960		12	11520
НИЙТ						11640
Шаардлагатай хүний нөөц = 11640 / 60 минут = 98 / 8 = 24.25 хүн						

## Хүний нөөцийн зардал

Хүний нөөцийн зардлыг тооцохдоо тухайн ажил үйлчилгээ буюу үүргийг гүйцэтгэх төрийн захиргааны байгууллагын албан хаагчид зарцуулах цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал зэрэг төрөөс даадаг бүх зардлыг нэгтгэн авч үзэх ба эдгээрийн дундаж хэмжээгээр тооцож тогтооно.

Монгол улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 472 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар Санхүүгийн зохицуулах хорооны албан хаагчдад хамаарах албан тушаалын цалингийн сүлжээг шинэчлэн баталсан.

Санхүүгийн зохицуулах хорооны референт нь АА-6 зэрэглэлд хамаардаг бөгөөд АА-6 5 шатлалаар тооцоход сарын цалин 1,128,170 төгрөг байна.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүний үндсэн цалингаас гадна 1/ бүх төрлийн даатгал, 2/ хоол, унааны нэмэгдэл, 3/ ажилласан жилийн нэмэгдэл, 4/ зэрэг дэвийн нэмэгдэл, 5/ буцалтгүй тусламж, 6/ шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Эдгээрийн хэмжээг тодорхой тогтоох боломжгүй тохиолдолд нэг албан хаагчийн цалингийн дундаж хэмжээний 15%-иар нийтлэг зардлыг, 10%-иар дагалдах зардлыг, 30%-иар нэмэгдэл, урамшууллын зардлыг тооцох боломжтой юм.

### Нэг албан хаагчид ногдох цалингийн зардал

Зардлын нэр	Цалингийн хэмжээ	Хувь	Хэмжээ
Үндсэн цалин	1128170		1,128,170₮
Нийтлэг зардал	1128170	15	169,226₮
Дагалдах зардал	1128170	10	112,817₮
Нэмэгдэл, урамшууллын зардал	1128170	30	338,451₮
Нийт			1,748,664₮

## Материаллаг зардал

Материаллаг зардал гэдэгт тухайн ажлын байртай холбоотой нийтлэг зардал буюу тухайн үүргийг гүйцэтгэж буй албан хаагчийг ажиллах нөхцөлөөр хангахад зарцуулж буй зардлыг хамааруулдаг. Тухайлбал, ажлын байр, эд хөрөнгө, техник хэрэгсэл, тэдгээрийн элэгдэл хорогдол, бусад ахуйн зардлыг тооцох шаардлагатай.

Тус зардлыг тооцохдоо "Хууль, хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал" 16-д үзүүлсэн Хууль зүй, дотоод хэргийн яамны нэг ажилтанд зарцуулагдах материаллаг зардлыг ашиглалаа.

Тус тооцоогоор нэг ажлын байрны нийт дундаж материаллаг зардал /1 жилээр/ хангамж, бараа материалын зардал /7,331,812₮/ + Байр, өрөө тасалгааны ашиглалттай холбоотой зардал /1,118,837₮/ + Урсгал засвар /2,456,000₮/ + Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж /210,753₮/ + Элэгдэл хорогдлын зардал /325,670₮/ нийт 11,443,072₮ байна.

### **Бусад зардал**

Хувийн тэтгэврийн тухай хуулийн төслийн 4.1 дүгээр хэсэгт "Ажилтан буюу даатгуулагч хүсэлт гарган Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т заасан Тэтгэврийн даатгалын санд төлөх шимтгэлийн даатгуулагчийн хоёр хувь болон ажил олгогчийн хоёр хувь, нийт дөрвөн хувийг өөрийн сонгосон Хувийн тэтгэврийн санд төлж болно" гэж заасан.

Өнгөрсөн онд ажил олгогч, албан журмын тэтгэврийн даатгалын шимтгэл нийт 17 хувь байсан ба улсын тэтгэврийн даатгалын санд 1376.4 тэрбум төгрөгийн орлоготой байжээ. Дээрх заалтын дагуу нийт нийгмийн даатгалын шимтгэл төлж буй иргэдийн 70 хувь хувийн тэтгэврийн санд хамрагдана гэж тооцож үзвэл 226.7 тэрбум төгрөгийг хувийн тэтгэврийн санд шилжүүлэхээр байна.

Энэ нийгмийн даатгалын сангийн алдагдлыг дээрх хэмжээгээр нэмэгдүүлж болзошгүй.

### **Зардлыг нэгтгэн тооцох**

Энэ үе шатанд улсын төсвөөс гарах нийт зардлыг тооцож гаргана.

Хувийн тэтгэврийн сангийн тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр 2 ажлын байр бий болно. Нэг албан хаагчид жилд цалингийн зардал  $1748664 \times 12 = 20983968₮$ , материаллаг зардал 11443072 төгрөг болох ба нийт хүний нөөцийн зардал 64854080₮ болохоор байна.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор нийгмийн даатгалын сангийн орлого 226.7 тэрбум төгрөгөөр буурах магадлалтай байгааг анхаарах нь зүйтэй.